



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ
АУДИТЫН КОД: ХОА-2025/07-20-ШТА-ГА

Ховд хот
2025 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsuren.a@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Мөнхтулга
Цахим хаяг: munkhtulgad@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Бадрал Цахим хаяг:
Badralts@audit.gov.mn
Ахлах аудитор:А.Нарандэлгэр
Цахим хаяг: narandelgera@audit.gov.mn



ХҮСНЭГТ БОЛОН ГРАФИКИЙН ТОВЬЁГ	2
<i>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</i>	3
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	5
БҮЛЭГ 1. ОРЛОГЫГ 5,010.8 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ, ТАТВАРЫН БУС ОРЛОГЫГ ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА	6
<i>Татварын орлогыг 2,863.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна</i>	6
<i>Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөлтийг оновчтой болгон 37.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, уул уурхайн экспортын бүтээгдэхүүнээс 2,109.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх нөөц боломж байна</i>	8
БҮЛЭГ 2. НИЙТ ЗАРЛАГЫГ 9,616.3 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАН 14,642.5 САЯ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬ, ЖУРМЫН ШААРДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА	9
<i>Урсгал зардлыг өмнөх оноос 14.5 хувиар буюу 9,616.3 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн ч илүү төлөвлөсөн 1,028.3 сая төгрөгийн зардлыг дахин хуваарилах шаардлагатай байна</i>	9
<i>Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баримтлаагүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй ажлуудыг санхүүжүүлэхээр төлөвлөжээ</i>	11
БҮЛЭГ 3. ӨМНӨХ АУДИТЫН ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСВИЙН 40 ХУВИЙГ ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛД ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА	12
<i>Төсвийн төсөлд төсөвлөлтийн шаардлага хангаагүй, иргэдийн санал аваагүй хөтөлбөр арга хэмжээг төлөвлөсөн нь хөрөнгө оруулалтын өгөөжийг бууруулж байна</i>	12
<i>Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй байна</i>	14
ЗӨВЛӨМЖ:	15
ХАВСРАЛТУУД	16

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БОНХОХБТХ	Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
БХС	Байгаль хамгаалах сан
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗС	Замын сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СЯ	Сангийн яам
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл

ХАВСРАЛТЫН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Эмч, багш нарын цалингийн нэмэгдлийн тооцоолол	16
Хавсралт 2	Галт зэвсгийн татварын тооцоолол	16
Хавсралт 3	Хог хаягдлын хураамжийн судалгаа	17
Хавсралт 4	Усны төлбөр төлөгч байгууллагуудын судалгаа	18
Хавсралт 5	Түүхий нүүрс олборлогч аж ахуй нэгжүүдийн агаарын бохирдлын төлбөрийн судалгаа /2024 оны олборлолтод үндэслэсэн/	20
Хавсралт 6	Тефис майнинг ХХК-ны 2024.01.01-2025.11.12-ны хүртэл экспортолсон нүүрсний мэдээ	20
Хавсралт 7	Түрээсийн орлогын судалгаа	20
Хавсралт 8	Зураг төсөвгүй төсөл арга хэмжээний судалгаа	21
Хавсралт 9	Ерөнхий нэршлээр баталсан төсөл арга хэмжээний судалгаа	21

ХҮСНЭГТ БОЛОН ГРАФИКИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Татварын газарт бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын судалгаа	6
Хүснэгт 2	Газрын төлбөрийн судалгаа	7
Хүснэгт 3	Аймгийн 2026 оны төсөвт орлого нэмэгдүүлэх саналын товчоо	9
Хүснэгт 4	Зарлагын судалгаа	9
Хүснэгт 5	Орон тооны судалгаа	10
Хүснэгт 6	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалт	11
Хүснэгт 7	Иргэдийн санал аваагүй төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээний судалгаа	11
Хүснэгт 8	Төсөл арга хэмжээний санхүүжилтийг зөрүүтэй тооцсон	12
Хүснэгт 9	Урсгал үйл ажиллагааны зардал	13
Хүснэгт 10	Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт	14

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь “Монгол Улсын Засгийн газар /цаашид “Засгийн газар” гэх/-аас Монгол Улсын Их Хурал /цаашид “Улсын Их Хурал” гэх/-д өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх Монгол Улсын жилийн төсвийн төсөл, түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал, Засгийн газар болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх” заалт Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйл, МУЕА-ын 2022 оны А/67 дугаар тушаалаар “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”, Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд “Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” аудитыг гүйцэтгэлээ.</p>
Аудитын зорилт	<p>Ховд аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн төсөлд дүн шинжилгээ хийж, төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.</p> <p>Дээрх зорилготой холбоотой дараах асуудлын хүрээнд аудитыг төлөвлөж гүйцэтгэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">➤ Төсвийн орлого нэмэгдүүлэх нөөц боломж байгаа эсэх,➤ Төсвийн төсөлд зарлага бууруулах боломжийг бүрэн тусгасан эсэх,➤ Төсвийн төсөлд төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх боломжийг бүрэн тусгасан эсэх,
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	<p>Аудитыг АДБОУС (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглав.</p>
Аудитын хамарсан хүрээ	<p>Ховд аймгийн Засаг даргаас Сангийн яаманд өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн төсөл, Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Татварын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, ОНӨГазар, Байгаль орчны газар, Үенч-Бодонч голын сав газрын захиргаа, Хар нуур Ховд голын сав газрын захиргаа зэрэг шалгагдагч болон хамрагдагч этгээдээс ирүүлсэн холбогдох баримт материалыг хамруулан гүйцэтгэлээ</p>
Аудитын арга зүй	<p>Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитад АДБОУС (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий Аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-д заасан арга зүйг</p>



<p>Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт</p>	<p>ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад дурдсан мэдээлэлд судалгаа, шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тодруулга авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, үр дүнг тооцох арга зүйг ашиглан дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p> <p>Аудитад дараах хууль, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.</p> <ul style="list-style-type: none">- Төрийн Аудитын тухай хууль- Төсвийн тухай хууль- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,- Төрийн хэмнэлтийн тухай хууль- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль- Татварын ерөнхий хууль болон бусад хууль- Монгол Улсын Ерөнхий аудиторын А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”- Сангийн яамны 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”- Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл
<p>Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар хянан удирдаж, аудитын менежер А.Цэцэгсүрэн аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналт хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Мөнхтулга, А.Нарандэлгэр, Б.Бадрал аудитор М.Энхжаргал, Н.Ариунтуяа, У.Батчимэг, Н.Батжаргал, Т.Бат-Эрдэнэ, Д.Нямгарав, Ц.Аззаяа, Н.Батзул, С.Оюунжаргал нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2025 оны 11 дугаар сарын 04-ний өдрөөс 11 дүгээр сарын 25-ныг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.</p>
<p>Хүндрэл бэрхшээл</p>	<p>Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1¹-д заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад албан бичиг ирүүлсэн ч хавсралт баримт материалыг бүрэн ирүүлээгүй, хөрөнгө оруулалтын жагсаалт нь хэд хэдэн удаа өөрчлөгдсөн нь аймгийн ИТХ-д хуульд заасан хугацаанд төсвийг дүгнэлт гаргахад хүндрэлтэй байлаа.</p>


¹ аймаг, нийслэлийн Засаг дарга, улсын зэрэглэлтэй хотын Захирагч тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Зөвлөлд өргөн мэдүүлэх

**ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Ховд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны орон нутгийн төсвийн төсөлд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь "...аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, ... аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх" гэж заасны дагуу Ховд аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж, дүгнэлт гаргав.

Ховд аймгийн ТЕЗ-ын 2026 оны төсвийн орлогыг нийт дүнгээрээ 97,396.6 сая төгрөгөөр төлөвлөсний 63.2 хувь буюу 61,627.7 сая төгрөгийг татварын, 2.9 хувь буюу 2,879.9 сая төгрөгийг татварын бус орлогоор, 4.7 хувь 4,570.7 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 0.9 хувь буюу 878.1 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэгээр, 19.5 хувь буюу 18,950.1 сая төгрөгийг ОНХС-ийн орлогын шилжүүлгээр, 8.7 хувь буюу 8,440.0 сая төгрөгийг Хөшөөт хөгжил сангаас, 0.1 хувь буюу 50.0 сая төгрөгийг өмчийн дуудлага худалдаа, бусад эх үүсвэрээр бүрдүүлэхээр тус тус төлөвлөжээ.

Аймгийн ТЕЗ-ийн 2026 оны төсвийн суурь орлогыг 47,481.2 сая төгрөгөөр төлөвлөн Сангийн яаманд хүргүүлж, Сангийн яамнаас хувь хүний орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, татварын бус орлогуудыг хянан 55,437.0 сая төгрөгөөр, ОНХС-гийн орлогын шилжүүлгийг 18,950.1, нийт 74,387.1 сая төгрөгөөр хянан ирүүлсэн байна.



Орон нутгийн 2026 оны төсвийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэлийн дагуу аймгийн ТЕЗ нь Сангийн яамнаас хянасан орлогыг 22,131.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүнд: Урьд оны үлдэгдлээс 4,570.7 сая, Хөшөөт хөгжил сангаас 8,440.0 сая, эрүүл мэнд, боловсролын салбарын цалингийн нэмэгдэлтэй холбоотой хүн амын орлогын албан татварыг 2,296.4 сая, үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогыг 330.7 сая, газрын дуудлага худалдааг 1,000.0 сая, байгалийн ургамал ашигласны төлбөрийг 16.0 сая, агаарын бохирдлын татварыг 5,000.0 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 27.5 сая, бусад орлогыг 450.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч 2026 оны нийт зарлагыг өмнөх онтой харьцуулахад 30,632.4 сая төгрөгөөр бууруулан 97,396.6 сая төгрөгөөр төлөвлөсөн нь урсгал зардлыг 9,613.3 сая, хөрөнгийн зардлыг 18,509.4 сая төгрөгөөр тус тус бууруулсантай холбоотой байна.

**БҮЛЭГ 1. ОРЛОГЫГ 5,010.8 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ, ТАТВАРЫН БУС ОРЛОГЫГ ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА****Татварын орлогыг 2,863.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна**

1.1 Ховд аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, “Алсын хараа-2050”, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулсан байна.

1.2 Татварын орлогыг 2024 оны гүйцэтгэлээс 10,063.3 сая, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 9,081.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн 61,627.7 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

1.3 2026 оны төсвийн төсөлд цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хувь хүний орлогын албан татварын орлогыг сангийн яамнаас 29,300.0 сая төгрөгөөр хянан баталгаажуулснаас эмч, багш нарын цалинг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шат дараатай нэмэгдүүлэх тул 2,296.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 31,596.4 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

1.4 Ховд аймгийн Боловсрол, эрүүл мэндийн салбарын 2025 оны цалингийн сангийн төсвөөс тооцоолбол 2026 онд ойролцоогоор 2,765.5 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татвар төвлөрүүлэхээр байгаа бөгөөд төсвийн орлогыг 469.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна. (Хавсралт №1)

1.5 Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.1-д Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 60 хувийг улсын төсвийн орлого байхаар, 23.6.10-т уг татварын 40 хувийг орон нутгийн төсвийн орлого байхаар тус тус заасан тул 2026 оны төсөвт уг татварын орлогыг Сангийн яамны хянасан дүнгээр буюу 16,200.0 сая төгрөгөөр төлөвлөжээ.

1.6 Үл хөдлөх хөрөнгийн татварын орлогыг 2025 онд 1,098.0 сая төгрөгөөр төлөвлөж, хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 1,144.1 сая төгрөг орохоор байхад 2026 онд 1,080.7 сая төгрөгөөр төлөвлөжээ. Үл хөдлөх хөрөнгийн татварын тухай хуульд 2024 оноос хойш татварын хувь хэмжээтэй холбоотой өөрчлөлт ороогүй бөгөөд үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дахь хэсгийн дагуу Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2012 оны 02/03 дугаар тогтоолоор Жаргалант суманд 0.8 хувь, бусад сумдад 0.6 хувь байхаар тогтоосон байна.

Хүснэгт №1 Татварын газарт бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын судалгаа /сая төгрөгөөр/

№	Сумын нэрс	Татвар төлөгчийн тоо	Татварын гүйцэтгэл-10 сарын байдлаар
1	Алтай	12	1.8
2	Булган	82	15.3
3	Буянт	16	336.4
4	Дарви	34	66.0
5	Дөргөн	26	22.5
6	Дуут	23	1.6
7	Жаргалант	352	494.6
8	Зэрэг	21	2.0
9	Манхан	23	2.9
10	Мөнххайрхан	20	1.8
11	Мөст	22	1.3
12	Мянгад	17	2.1
13	Үенч	35	1.9
14	Ховд	24	1.3
15	Цэцэг	36	5.5
16	Чандмань	12	1.9
17	Эрдэнэбүрэн	11	1.6
ДҮН		766	960.3

Эх сурвалж: аймгийн Татварын газраас ирүүлсэн мэдээлэл

1.7 Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасны дагуу галт зэвсгийн албан татварын орлогыг Ховд аймгийн хэмжээнд тоологдсон бууны судалгаатай уялдуулан тооцвол 2026 оны төсвийн төсөлд тусгасан 49.0 сая төгрөгийн орлогыг 37.2 сая



төгрөгөөр нэмэгдүүлэн 86.2 сая төгрөгийн орлого бүрдүүлэх боломжтой байна. (Хавсралт №2)

1.8 Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг 2025 онд 2,681.0 сая төгрөгөөр төлөвлөж, хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 2,989.6 сая төгрөг төвлөрөхөөр байхад 2026 онд 700.0 сая төгрөгөөр төлөвлөсөн нь Гадаадын иргэн харьяатын Баруун бүс дэх газрын улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд 2024 оноос, зөвшөөрлийн тухай хуульд 2025 оны 5 сараас хойш татварын хувь хэмжээтэй холбоотой өөрчлөлт ороогүй бөгөөд энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр тооцоход 200.0 сая орчим төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

1.9 Хог хаягдлын хураамжийн тухай хуулийн 9.2.2²-д заасны дагуу сумдын ИТХ-ын тогтоолоор хог хаягдлын хураамжийн орлогыг айл, өрх, төсөвт байгууллага, аж ахуйн нэгж болон бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага бүрээр сар, жилээр тооцон орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан.

1.10 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 2026 оны төсвийн төсөлд 80.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр баталсан ч бодитой тоо мэдээлэлд үндэслээгүй, сумдын ИТХ-аар баталсан хог хаягдлын үйлчилгээний хураамж тогтоох тухай тогтоолтой уялдуулан төлөвлөөгүй тул 163.8 сая төгрөгийн орлого нэмж бүрдүүлэх боломжтой байна. (Хавсралт №3)

1.11 Алтай, Дарви, Үенч, Зэрэг сумдын ИТХ-аас уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдээс хог хаягдлын хураамж тариф тогтоосон тогтоол баталсан боловч бусад сумууд хог хаягдлын хураамжийг тогтоогоогүй байна.

1.12 Жаргалант сумаас бусад сумууд дулаан үйлдвэрлэж, түгээж байгаа байгууллагуудаас хог хаягдлын хураамжийн тариф тогтоогоогүй байна.

1.13 Газрын төлбөрийн орлогыг хянаж үзэхэд 2026 онд 1,100.0 сая төгрөг байхаар тусгасан бөгөөд Мянгад сумын нутагт орших Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн буудлагын зориулалтаар эзэмших 3,028.2 га газрын төлбөрийн 925.7 сая төгрөгийг тус байгууллагын төсөвт тусгаагүй, газрын төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт төлөвлөөгүй байна. Газрын төлбөрийн тухай хууль, бусад эрх зүйн актуудаар тус байгууллагын эзэмшиж буй газрын төлбөрийг чөлөөлөх үндэслэл байхгүй байна. Газрын төлбөрийн өр төлбөртэй холбоотой 400 орчим сая төгрөг байгаа талаар холбогдох мэргэжилтнээс мэдээлсэн ба 2026 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд батлах чиглэлд төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, төсвийн орлогын бааз суурийг өргөтгөх, татварын ногдол болон хуримтлагдсан татварын өр төлбөрийг барагдуулах гэсний дагуу тооцвол 900 орчим

Хүснэгт №2 Газрын төлбөрийн судалгаа

/ сая төгрөгөөр/

№	Сумдын нэрс	Хуулийн дагуу ногдуулсан газрын төлбөр /2025 он/	Төлөвлөж буй газрын төлбөр /2025 он/
1	Алтай	6.2	6.2
2	Булган	28.0	28.0
3	Буянт	27.7	27.7
4	Дарви	362.9	362.9
5	Дөргөн	20.3	20.3
6	Дуут	5.5	5.5
7	Жаргалант	169.3	169.3
8	Зэрэг	4.5	4.5
9	Манхан	6.2	6.2
10	Мөнххайрхан	4.9	4.9
11	Мөст	6.2	6.2
12	Мянгад	947.9	22.2
13	Үенч	29.6	29.6
14	Ховд	10.1	10.1
15	Цэцэг	22.7	22.7
16	Чандмань	7.0	7.0
17	Эрдэнэбүрэн	5.1	5.1
	ДҮН	1,664.3	738.5
	Өр / ойролцоогоор /	400.0	400.0
	НИЙТ ДҮН	2,064.3	1,138.5

Эх сурвалж: ГХБХБГ-аас ирүүлсэн мэдээлэл

² Энэ хуулийн 8.7.1-д заасан аргачлалын дагуу тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох



сая төгрөгийн орлого төлөвлөх боломжтой байна. Гэвч энэ нь төсвийн байгууллагын төсөвт суугаагүйгээс орлого биелэхгүй байх шалтгаан болж болзошгүй байна.

1.14 Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас 2026 онд шинэ суурьшлын бүсийн 14 байршилд үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын газрыг дуудлага худалдаагаар олгохоор төлөвлөсөн бөгөөд 2026 оны төсвийн төсөлд газрын дуудлага худалдааны орлогыг 1,100.0 сая төгрөгөөр тусгасан байна.

1.15 Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.27³ дахь заалт, 31⁴ дүгээр зүйлд заасны дагуу ус ашигласны төлбөрийг мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн тоо мэдээ судалгаанд үндэслэн тооцоогүйгээр өнгөрсөн оны төлөвлөгөөг 51 хувиар бууруулан тооцсон бөгөөд Аймгийн БОАЖГ, Хар нуур Ховд голын сав газрын захиргаа, Үенч Бодонч Булган сав газрын захиргаанаас дулаан хангамж, хайгуул, тээвэр, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудын судалгаанаас үзэхэд 215.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр байна. Уг тооцооллоос үзэхэд ус ашиглуулсны төлбөрийн орлогыг 93.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна. (Хавсралт №4)

1.16 Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1⁵, Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолд заасны дагуу Орон нутагт томоохон уул, уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллах гэрээний дагуу 2026 онд МоЭнКо компаниас 8,440.0 сая төгрөгийн орлогыг орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэхээр тооцсон байна.

1.17 Агаарын бохирдлын төлбөрийг 2026 оны төсвийн төсөлд шинээр 5,000.0 сая төгрөг байхаар төлөвлөжээ.

1.18 Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1⁶, 7.2⁷-д заасны дагуу 2026 оны 6 сарын 1-ний өдрөөс эхлэн агаарын бохирдлын төлбөр нь орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр болсонтой холбогдуулан түүхий нүүрс экспортлогч аж ахуй нэгж байгууллагын 2024 оны суурь мэдээлэлд үндэслэн тооцоход 6,971.0 сая төгрөг ногдуулахаар байгаагаас харахад уг татварын орлогыг 1,900.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна. (Хавсралт №5)

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөлтийг оновчтой болгон 37.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, уул уурхайн экспортын бүтээгдэхүүнээс 2,109.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх нөөц боломж байна

1.19 2025 онд гэрээ байгуулах шатанд байгаа Тефис майнинг ХХК-ний 2024, 2025 оны нүүрсний экспортын дүнгээс харахад 2026 оны орон нутгийн төсөвт багадаа 2,109.4 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх боломжтой байна. (Хавсралт №6)

1.20 Орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-гийн хөрөнгөөр сумдын ЗДТГ-д бүртгэгдсэн ковш, хогны машин бүртгэлд авч гэрээгээр ашиглуулж байгаа, аймаг, сумуудад ашиглалтад орсон спорт заалнаас өөрийн орлогыг төлөвлөөгүй, аймгийн хэмжээнд 37.5 сая төгрөгийн орлого тооцоогүйгээр төсөвлөсөн байна. (Хавсралт №7)

1.21 Сумуудын удирдлагуудаас тухайн суманд бүртгэлтэй техник хэрэгслийг суманд хариуцан ажиллуулах хүнгүй, эвдэрсэн тохиолдолд сэлбэг хэрэгсэл авах төсөв, санхүүгүй, түрээслэх эрх зүйн зохицуулалт, зөвлөмж чиглэл тодорхойгүй, сум, орон нутагт байнга ашиглах боломжгүй, хүйтний улиралд байлгах граж байхгүй, ихэнхдээ айлын хашаанд

³ 3.1.27."ус ашиглагч" гэж ашиг олох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээндээ ус, усан орчин, рашааныг ашигладаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг;

⁴ Ус ашигласны төлбөр

⁵ Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

⁶ Олборлосон түүхий нүүрсний төлбөрийн хувь, хэмжээг нүүрсний килограмм тутамд 1-2 төгрөгийн хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тогтооно.

⁷ Үйлдвэрлэсэн болон импортлосон органик уусгагчийн төлбөрийн хувь, хэмжээг органик уусгагчийн килограмм тутамд 10-30 төгрөгийн хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тогтооно.



хадгалагдах байдалтай, зарим нь жилд цөөхөн ашигладаг, зарим нь одоо болтол бичиг баримтгүй гэх мэт асуудлууд тулгарч байна.

1.22 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй”, 2.1-д “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах”, 2.2-д “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх”, 78 дугаар зүйлийн 2-д “Хуульд өөрөөр заагаагүй бол Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 2.1-д “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах” гэж заасан эрхийн хүрээнд тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлснээр төсвийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт сайжирч, төсвийн үр ашиг нэмэгдэх боломжтой байна.

Хүснэгт №3 Аймгийн 2026 оны төсөвт орлого нэмэгдүүлэх саналын товчоо /сая төгрөгөөр/

№	Орлогын төрөл	Нэмэгдүүлэх санал
1	Хувь хүний орлогын албан татвар	469.1
2	Галт зэвсгийн албан татвар	37.2
3	Улсын тэмдэгтийн хураамж	200.0
4	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	163.8
5	Ус рашаан ашигласны төлбөр	93.8
6	Агаарын бохирдол	1,900.0
Татварын орлогын дүн		2,863.9
7	ОНХС-д төвлөрүүлэх орлого	2,109.4
8	Төсөвт байгууллагын өөрийн орлого	37.5
Татварын бус орлогын дүн		2,146.9
Нийт орлого		5,010.8

1.23 Аймгийн 2026 оны төсвийн төсөлд 6 нэр төрлийн татварын орлогыг 2,863.9 сая төгрөгөөр, 2 нэр төрлийн татварын бус бусад орлогыг 2,146.9 сая төгрөгөөр, нийт төсвийн орлогыг 5,010.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байгааг аймгийн ИТХ-д уламжилж байна.

БҮЛЭГ 2. НИЙТ ЗАРЛАГЫГ ӨМНӨХ ОНООС 9,616.3 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛСАН Ч ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬ, ЖУРМЫН ШААРДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Урсгал зардлыг өмнөх оноос 14.5 хувиар буюу 9,616.3 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн ч илүү төлөвлөсөн 1,028.3 сая төгрөгийн зардлыг дахин хуваарилах шаардлагатай байна

2.1 Ховд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийг Сангийн яамнаас урсгал зардлыг 51,749.3 сая төгрөг, хөрөнгийн зардлыг 23,516.0 сая төгрөг, нийт зардлыг 75,265.3 сая төгрөгөөр тус тус хянажээ.

Хүснэгт №4 Зарлагын судалгаа(сая,төг)

2.2 Төсвийн ерөнхийлөн захирагч 2026 оны нийт зарлагыг өмнөх онтой харьцуулахад 30,632.4 сая төгрөгөөр бууруулан 97,396.6 сая төгрөгөөр төлөвлөсөн нь урсгал зардлыг 9,613.3 сая, хөрөнгийн зардлыг 18,509.4 сая төгрөгөөр тус тус бууруулсантай холбоотой байна.

Эдийн засгийн ангилал	СЯ-ны хянасан	2026 оны санал	Зөрүү
Урсгал зардал	51,749.3	56,604.5	4,855.2
Хөрөнгийн зардал	23,516.0	40,792.1	17,276.1
Нийт зардал	75,265.3	97,396.6	22,131.3

Эх сурвалж: Орон нутгийн төсвийн 2026 оны санал

2.3 Орон нутгийн төсвийн нийт зардлын 58 хувь буюу 56,604.5 сая төгрөгийг орон нутгийн байгууллагуудын урсгал зардалд, 42 хувь буюу 40,792.1 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын зардалд хуваарилсан байна.

2.4 Төсвийн урсгал зардлыг 2025 оны төсөвтэй харьцуулахад 14.5 хувь буюу 9,616.3 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн ч хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах зардлуудыг шинээр нэмж төлөвлөсөн байна. Тухайлбал:

- Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн 79 албан хаагчтай холбоотой 723.6 сая төгрөг,



- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн хянасан орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой 672.9 сая төгрөг,
- Гэр бүл хүүхэд хөгжлийн газрын түр хамгаалах байрны зардалд 120.0 сая төгрөг
- Камерын хяналтын төвийн зардалд 244.0 сая төгрөг,

2.5 Сангийн яамнаас 15 төрийн албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардалд 131.1 сая төгрөгөөр дутуу төлөвлөснийг орон нутгийн төсвийн саналд 374.0 сая төгрөгөөр бүрэн олгохоор тусгажээ.

2.6 Хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх үйлчилгээний зардлын ангилалд сумдын ЗДТГ-ын 78.5 сая, сумдын ИТХ-ын 73.0 сая, Орон нутгийн өмчийн газрын 4.5 сая, нийт 156.1 сая төгрөгийн зардлыг төсөвлөлтийн шаардлага хангаагүй, тооцоо судалгаагүй төлөвлөжээ.

2.7 Монгол улсын Засгийн газрын 2025 оны 37 дугаар тогтоолоор архивын тасгийг агентлагийн эрх зүйн байдалд шилжүүлсэнтэй холбогдуулан Архивын тухай хууль, архивын дүрэмд нийцүүлэн архивын хэлтсийн бүтцийг шинээр баталж, орон нутгийн төсөвт 412.0 сая төгрөгийг хуваарилсан нь Монгол улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд заасан төрийн албаны бүтцийг тэлэхгүй байх, төрийн албыг цомхон давхардалгүй байх, чадварлаг бүтцээр ажиллуулах зорилттой нийцээгүй байна.

Хүснэгт №.5 Орон тооны мэдээллийн судалгаа

Төсөвт байгууллага	9 хувиар бууруулсан орон тоо	2026 оны төсвийн саналд	зөрүү /илүү/	Цалингийн зөрүү /сая.төг/
Аймгийн ИТХ	13	15	2	65.1
Аймгийн ЗДТГ	88	97	9	252.1
Нийт	101	112	11	317.2

Эх сурвалж: Орон нутгийн төсвийн 2026 оны санал

2.8 Зарим байгууллагуудын бүтэц, орон тоог тулган баталгаажуулахад Монгол улсын Засгийн газраас багш эмч нараас бусад төрийн албан хаагчдын орон тоог 9 хувь бууруулах бодлогын арга хэмжээг мөрдөөгүйгээс аймгийн ЗДТГ 8, аймгийн ИТХ 2 орон тоог тус тус илүү тусгаснаас 317.2 сая төгрөгийн цалингийн зардлыг бууруулах боломжтой байна.

2.9 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны урсгал зардлын төсөвт дараах 299.1 сая төгрөгийн зардлуудын хасаж төсвийн үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд албан хаагчид орон байрны дэмжлэг үзүүлэхээр Сангийн яамны хянасан дүнгээс 21.0 сая төгрөгөөр илүү төлөвлөсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3- дахь хэсэгт “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэж заасантай нийцээгүй,
- Аймгийн ИТХ-ын цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 78.1 сая төгрөгөөр бодит гүйцэтгэлээс илүү төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцээгүй,
- Аймгийн нөөц бүрдүүлэлт, зарцуулалтын үр дүнд хийсэн хийсэн гүйцэтгэлийн аудитаар Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг хянахад журамд нийцээгүй, төлөвлөх боломжтой 306.5 сая төгрөгийн зардлыг зарцуулсан зөрчил илэрч албан шаардлага өгсөн. Иймд Сангийн яамны хянасан дүнгээс тооцоо судалгаагүй нэмэгдүүлэн төлөвлөсөн 200.0 сая төгрөг байна,

2.10 Иймд 2026 оны урсгал зардлыг хянахад аймгийн архивын тасагт төлөвлөсөн 412.0 сая, орон тоог бууруулахтай холбоотой 317.2 сая, илүү төлөвлөсөн 299.1 сая төгрөгийг тус тус бууруулан Монгол улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө, Засгийн газрын төрийн албаны бүтцийг тэлэхгүй байх, төрийн албыг цомхон давхардалгүй байх, чадварлаг бүтцээр ажиллуулах бодлоготой нийцүүлэх шаардлагатай байна.



Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баримтлаагүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй ажлуудыг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

2.11 Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 4,900.0 сая, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 16,581.4 сая, замын сангийн хөрөнгө оруулалтаар 2,226.0 сая төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барилга, байгууламжийн их засварын зардалд 2,339.8 сая төгрөг, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардалд 39.8 сая төгрөгийг нийт 26,087.0 сая төгрөгийг 2026 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт № 6 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ

Нэрс	ОНХО		ОНХС		БХС		ЗС		Их засвар	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Шилжих хөрөнгө оруулалт			9	3,780.6			2	1,053.3	3	921.6
Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	4	1,711.7	14	3,995.5			2	872.7	4	1,153.1
Их засвар	3	277.3	6	975.7			1	300.0	1	265.1
Тоног төхөөрөмж			2	388.0	1	19.8				
Төсөл хөтөлбөр, арга хэмжээ	3	2,911.0	20	7,441.6	1	20.0				
Нийт дүн	10	4,900.0	51	16,581.4	2	39.8	5	2,226.0	8	2,339.8

Эх сурвалж: Аймгийн CTCX-ээс ирүүлсэн 2026 оны төсвийн санал

2.12 Орон нутгийн төсвөөс 2026 онд хийгдэх хөрөнгө оруулалтын жагсаалтад 1,101.0 сая төгрөгийн өртөг бүхий 1,101.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 5 төсөл арга хэмжээний тооцоолол судалгаа, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй баталсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁸, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3⁹ дах заалтуудыг зөрчиж байна. (Хавсралт 8)

2.13 Аймгийн 2026 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад ерөнхий нэрээр баталсан, нэр, байршил нь тодорхойгүй 8,645.2 сая төгрөгийн 14 төсөл арга хэмжээг төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4¹⁰ дахь заалттай нийцээгүй. (Хавсралт 9)

2.14 2026 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад 2,269.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 4 төсөл арга хэмжээ нь төсөвлөлтийн шаардлагад нийцээгүй, иргэдийн санал аваагүй төлөвлөсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5¹¹ болон төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29^{1.12} - д заасантай нийцээгүй тул иргэдийн санал авч дэмжигдсэн төсөл арга хэмжээг төлөвлөх.

Хүснэгт 7 Иргэдийн санал аваагүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээ

№	Төсөл арга хэмжээний нэрс	Эх үүсвэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
1	МУИС-ын баруун бүсийн сургуулийн хашаа	ОНХС	2026	2026	19.8	19.8
2	ЖДҮ оролцоо	ОНХС	2026	2026	300.0	300.0
3	Хувийн хөрөнгө оруулалтаар ашиглалтанд орсон Спорт заалны дэмжлэг	ОНХС	2026	2026	50.0	50.0
4	Баялаг бүтээгчдийг дэмжих, бизнесийн орчин бүрдүүлэх арга хэмжээний зардлын санхүүжилт	ОНХО	2026	2026	1,900.0	1,900.0
	Нийт дүн				2,269.8	2,269.8

⁸ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁹ техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ

¹⁰ санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах

¹¹ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ

¹² Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна



2.15 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хувийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон спорт заалны дэмжлэгт 50.0 сая төгрөгийг төсөвлөсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3¹³, 13.3.2¹⁴ дахь заалтууд, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.7.6¹⁵ дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

2.16 Аймгийн 2026 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад төсөл арга хэмжээний санхүүжигдэх дүнг Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5¹⁶ дахь заалтыг зөрчин зөрүүтэй тооцжээ.

Хүснэгт:8 ТАХ-ны санхүүжилтийг зөрүүтэй тооцсон

№	Төсөл арга хэмжээний нэрс	Эх үүсвэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Хашаандаа сайхан амьдарцгаая төслийн гэр хорооллын айл өрхийг цэвэр бохир усны шугамд холбох санхүүгийн дэмжлэг	ОНХС	2025	2027	2,970.1	100.0
2	Авто замын засвар, шинэчлэлт (Ховд аймаг, Жаргалант сум)	ОНХС	2025	2026	4,292.9	928.0
3	Шинэ суурьшлийн бүсийн 6.7 км замын зураг төсөл /Жаргалант сум/	Замын сан	2023	2027	271.6	121.6
4	Авто замын засвар, шинэчлэлт (Ховд аймаг, Жаргалант сум)	Замын сан	2025	2026	4,292.9	931.7
Нийт дүн					11,827.5	2,081.3

2.17 Ховд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн төсөлд төлөвлөсөн дээрх төсөл арга хэмжээнүүдийг хууль, журамд нийцүүлэн төлөвлөж, төлөвлөлтийн шаардлага хангасан хөрөнгө оруулалтын ажлуудад хуваарилах шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. ӨМНӨХ АУДИТААР ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСВИЙН 40 ХУВИЙГ ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛД ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА

